



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

ЭМ ЗҮЙН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ – 2022

Улаанбаатар хот
2022 он

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
УВН төв, 8 дугаар давхар

Утас: 260182

Э-шуудан: info@mmra.gov.mn
www.mmra.gov.mn

Эрхэлсэн: Ш.Энхтуяа *ЭЭХХЗГ-ын даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч*

Хянасан: П.Цэцгээ *ЭЭХХЗГ-ын ЭАБТС-ын газрын дарга*

Орчуулсан: С.Пүрэвсүрэн *Эм зүйн ухааны Доктор, Профессор*

Эмхэтгэсэн: Ц.Цэрэнчимэд *ЭЭХХЗГ-ын ЗУГ-ын мэргэжилтэн*

Мэдээлэл цуглуулсан:

Э.Одонтуяа	<i>ЭЭХХЗГ-ын ЧХГ-ын улсын байцаагч</i>
Э.Ундармаа	<i>ЭЭХХЗГ-ын ЭАБТСГ-ын мэргэжилтэн</i>
Н.Мөнхзаяа	<i>ЭЭХХЗГ-ын ЭХГ-ын мэргэжилтэн</i>
А.Номиндарь	<i>ЭЭХХЗГ-ын ЛЗЗГ-ын мэргэжилтэн</i>
М.Долгион	<i>ЭЭХХЗГ-ын ЭБХ-ийн ахлах мэргэжилтэн</i>
Э.Одбаяр	<i>ЭЭХХЗГ-ын ЭҮХ-ийн ахлах мэргэжилтэн</i>
Ш.Ариунзаяа	<i>ЭЭХХЗГ-ын ЭБХ-ийн мэргэжилтэн</i>
М.Тэгшсайхан	<i>ЭЭХХЗГ-ын ЭБХ-ийн мэргэжилтэн</i>
Д.Номинцэцэг	<i>ЭЭХХЗГ-ын ЭШЛ-ийн ахлах шинжээч</i>

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	4
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	5
1. ХҮН АМ ЗҮЙН БОЛОН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ	6
1.1 МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ	6
1.2 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ	8
1.2.1. ХҮН АМЫН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН	8
1.2.2. ХҮН АМЫН НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН	9
2. ЭМ ЗҮЙН САЛБАРЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ	10
2.1. ЭРХ ЗҮЙ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ	10
2.2. ЭМ ХАНГАМЖИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЗҮҮЛЭЛТ	14
2.2.1. ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ҮЙЛДВЭР	15
2.2.2. ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА	16
2.2.3. ЭМИЙН САН	16
2.3. ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ	18
2.4. ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	22
2.4.1. ЭМИЙН САНХҮҮЖИЛТ	22
2.4.2. ЭМИЙН ИМПОРТ	24
2.4.3. ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ИМПОРТ	25
2.4.4. УРВАЛЖ, СТАНДАРТ БОДИСЫН ИМПОРТ	26
2.4.5. ОНОШЛУУРЫН ИМПОРТ	26
2.4.6. ИМПОРТЫН ЛИЦЕНЗ	26
2.4.7. ЭМИЙН ЭКСПОРТ	28
2.4.8. ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТ	29
2.4.9. ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	31
2.5. ЭМИЙН ЗОХИЦУУЛАЛТ	32
2.5.1. ЭМИЙН БҮРТГЭЛ	32
2.5.2. ХЯНАЛТ ШАЛГАЛТ	35
2.5.3. ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ	37
2.5.4. ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ	39
2.5.5. ЭМИЙН СОНГОЛТ	40
2.5.6. ЭМИЙН ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ЗӨВШӨӨРӨЛ	41
2.5.7. ЭМИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ	42
2.5.8. МАНСУУРУУЛАХ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ ЭМ	43
2.6. ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ШАЛГАЛТ ТОХИРУУЛГА	45
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	49
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	50
ХАВСРАЛТ 1. ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ЭМИЙН 10 ДУГААР ЖАГСААЛТ	51
ХАВСРАЛТ 2. ХҮҮХДИЙН ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ЭМИЙН 3 ДУГААР ЖАГСААЛТ	76

ӨМНӨХ ҮГ



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас “Эм зүйн салбарын үзүүлэлт-2022” эмхэтгэлийг та бүхэндээ хүргэж байгаадаа таатай байна. Эм зүйн салбарын үндсэн үзүүлэлтийг эмхэтгэн, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч болон бусад хэрэглэгчдийн хүртээл болгох нь эрүүл мэндийн салбарын ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой билээ.

Эм зүйн салбарын үзүүлэлтийг эм зүйн салбарын хүний нөөц, эм хангамжийн байгууллага, эдийн засгийн тоон мэдээлэл болон эмийн бүртгэл, чанар аюулгүй байдал, эмийн сонголт хэрэглээний үзүүлэлтийг тусган 2015 онд анх эмхэтгэн гаргаж байсан ба энэ удаагийн найм дахь эмхэтгэлд нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээ, импорт, экспорт, мансууруулах, сэтгэц нөлөөт эмийн тоон үзүүлэлтийг дэлгэрүүлэн тусгасан онцлогтойгоор эрхэм хэрэглэгч Та бүхэнд толилуулж байна.

Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хөтөлбөрт тусгагдсан эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх зорилтын хүрээнд эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь чухлаар тавигдаж байна.

Салбарын бодлого, төлөвлөгөө, арга хэмжээ болон судалгаа шинжилгээний ажилд өргөнөөр ашиглана гэдэгт итгэж байна.

Ш.ЭНХТУЯА

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР


АУК	Анагаах Ухааны коллеж
АШУҮИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
БИБ	Биологийн идэвхт бүтээгдэхүүн
БӨЭТ	Бүсийн Оношилгоо, эмчилгээний төв
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард улс
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос улс
ЗШЭҮЖ	Зайлшгүй шаардлагатай эмийн үндэсний жагсаалт
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
ОХУ	Оросын Холбооны Улс
УНТЭ	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
УХТЭ	Улсын хоёрдугаар төв эмнэлэг
ХСҮТ	Хавдар судлалын үндэсний төв
ЭЗШУИС	Эм зүйн шинжлэх ухааны их сургууль
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭТТИ	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭХНБ	Эм ханган нийлүүлэх байгууллага
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
АТС	Anatomical Therapeutic Chemical
AWaRe	Access Watch Reverse (Хүртээмжтэй байлгах, хянах, нөөцлөх)
GMP	Good Manufacturing Practice (Үйлдвэрлэлд тавих зохистой дадал)
MNS	Mongolian National Standard (Монгол улсын стандарт)
PSUR	Periodic Safety Update Report (Эмийн аюулгүй байдлын хугацаат тайлан)
CIOMS	Council for International Organizations of Medical Sciences (Анагаахын шинжлэх ухааны олон улсын байгууллагын зөвлөл)

1.1. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ

Монгол улсын хүн амын тоо 2022 онд 3 сая 457.5 мянга болсон байна. 2021 оноос 47.6 мянган хүнээр буюу 3.88 хувиар өссөн байна. Нийт хүн амын 2 сая 424.6 мянга буюу 70.1% нь хот суурин газар, үлдсэн 1 сая 32.8 мянга буюу 29.9% нь хөдөө амьдарч байгаа бөгөөд эрэгтэйчүүд 1 сая 696.1 мянга, эмэгтэйчүүд 1 сая 761.4 мянга байна. (Зураг 1.)

Нийт хүн амын насны бүлгээр эзлэх хувийг авч үзвэл: 0-14 хүртэлх насны хүүхэд 31.9 хувь, 15-19 насны хүүхэд 6.7 хувь, 20-39 насны хүн ам 30.6 хувь, 40-64 насны хүн ам 25.9 хувь, 65-аас дээш насны хүн ам 4.7 хувийг тус тус бүрдүүлж байна.


Зураг 1. Хүн амын тоо, сонгосон онуудаар



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

Монгол хүний дундаж наслалт 2022 онд улсын хэмжээнд 71.3 болж өмнөх оноос 0.29 жилээр өссөн бөгөөд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 76.7, эрэгтэйчүүдийн хувьд 67.3 болсон байна. Монгол хүний дундаж наслалт 1965 онд 65.5 байсан ба сүүлийн 57 жилийн хугацаанд 5.8 жилээр нэмэгдсэн байна. (Зураг 2)

Зураг 2. Хүн амын дундаж наслалт, сонгосон онуудаар



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

Хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалт аймгуудаар авч үзвэл Баян-өлгий аймгийн хүн амын дундаж наслалт 75.7 буюу улсын дундажаас 4.4 жилээр их, Дархан-Уул аймгийн хүн амын дундаж 68.4 буюу улсын дундаж 2.9 жилээр бага байна. (Зураг 3.)

Зураг 3. Хүн амын дундаж наслалт, аймаг, нийслэлээр 2022 он



Хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалт аймаг бүсүүдээр ялгаатай байгаа ба зүүн бүсэд хамгийн өндөр буюу 73.3, төвийн бүсэд хамгийн бага буюу 72.4 бага байна.

Хүснэгт 1. Хүн амын дундаж наслалт, бүс, аймгаар 2022 он

Аймаг, нийслэл	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	71.3	67.3	76.7
Баруун бүс	73.0	69.5	75.7
Баян-Өлгий	75.7	72.7	77.8
Говь-Алтай	72.0	66.9	76.4
Завхан	72.9	70.4	75.0
Увс	70.8	66.4	74.0
Ховд	74.0	71.4	75.3
Хангайн бүс	72.5	69.8	75.4
Архангай	73.3	71.4	74.1
Баянхонгор	71.7	68.4	73.7
Булган	74.4	70.4	76.6
Орхон	73.6	72.2	84.4
Өвөрхангай	72.8	70.4	75.4
Хөвсгөл	69.5	66.1	74.4
Төвийн бүс	72.4	69.0	77.0
Говьсүмбэр	73.9	73.5	75.6
Дархан-Уул	68.4	63.8	74.4
Дорноговь	72.9	68.7	78.3
Дундговь	74.7	70.9	80.0
Өмнөговь	73.0	68.8	77.8
Сэлэнгэ	71.8	67.5	78.1
Төв	72.6	70.3	75.3
Зүүн бүс	73.3	69.4	77.3
Дорнод	70.8	66.7	75.1
Сүхбаатар	75.3	70.4	79.8
Хэнтий	73.8	71.2	77.1
Улаанбаатар	72.1	67.1	75.5

Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

1.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ


1.2.1. ХҮН АМЫН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН

Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд амьсгалын зам, хоол боловсруулах, зүрх судасны, шээс бэлгийн тогтолцооны өвчин болон гэмтэл хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг өвчнүүд багтаж байна. 2021 онд хоол боловсруулах тогтолцооны өвчин тэргүүлж байсан бол 2022 онд амьсгалын тогтолцооны өвчин тэргүүлж байна.

Хүн амын өвчлөлийн шалтгаан 10000 хүн амд авч үзвэл :	2021 он	2022 он
- Амьсгалын тогтолцооны өвчин	788.4	1822.6
- Хоол боловсруулах тогтолцооны өвчин	1354.2	1766.7
- Зүрх-судасны тогтолцооны өвчин	936.5	1308.9
- Шээс бэлгийн тогтолцооны өвчин	682.3	959.5
- Гэмтэл хордлого, нас баралтын гадны шалтгаан бусад тодорхой эмгэг	475.8	658.0

Урьд онтой харьцуулахад 10000 хүн амд амьсгалын тогтолцооны өвчин 1034.2-оор, хоол боловсруулах тогтолцооны өвчин 412.5-аар, зүрх-судасны тогтолцооны өвчин 372.4-аар, шээс бэлгийн тогтолцооны өвчин 272.2-аар, гэмтэл, хордлого ба бусад шалтгаант өвчин 182.4-ээр тус тус өссөн байна. (Зураг 4.)

Зураг 4. Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан, 10 000 хүн амд, 2011-2022 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн хөгжлийн төв, Эрүүл мэндийн салбарын үзүүлэлт-2022 он


1.2.2. ХҮН АМЫН НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН

Монгол улсын хүн амын нас баралтын шалтгаанд амьсгалын тогтолцооны өвчин, хавдар, зүрх-судасны тогтолцооны өвчин 1990 онд тэргүүлж байсан бол 1995 оноос одоог хүртэл зүрх-судасны тогтолцооны өвчин, хавдар, гэмтэл, хордлого, гадны шалтгаант нас баралт тэргүүлсээр байна.

Хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан 10 000 хүн амд:	2021 он	2022 он
- Зүрх-судасны тогтолцооны өвчин	18.9	17.5
- Хавдар	12.9	12.8
- Гэмтэл хордлого, нас баралтын гадны шалтгаант	9.2	10.1
- Хоол боловсруулах тогтолцооны өвчин	3.5	3.7
- Амьсгалын тогтолцооны өвчин	2.9	2.7

Урьд онтой харьцуулахад хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан 10000 хүн амд зүрх-судасны тогтолцооны өвчин 1.4, хавдар 0.1, амьсгалын тогтолцооны өвчин 0.2-оор тус тус буурч, гэмтэл, хордлого ба бусад шалтгаант өвчин 0.9, хоол боловсруулах тогтолцооны өвчин 0.2-ээр тус тус өссөн байна. (Зураг 5.)

Зураг 5. Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүн амд (2009-2022 он)



Эх үүсвэр: Эрүүл мэндийн хөгжлийн төв, Эрүүл мэндийн салбарын үзүүлэлт-2022 он

2.1. ЭРХ ЗҮЙ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

2022 оны байдлаар Монгол улсын эм зүйн салбарт дараах эрх зүйн баримт бичгийг мөрдөн ажиллав.

ХУУЛЬ (цагаан толгойн үсгийн дарааллаар):

1. Авлигын эсрэг хууль (2006 оны 07 дугаар сарын 06-ний өдөр)
2. Аудитын тухай /Шинэчилсэн найруулга/ (2015 оны 06 дугаар сарын 19-ний өдөр)
3. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай /Шинэчилсэн найруулга/ (2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр)
4. Байгууллагын нууцын тухай (1995 оны 05 дугаар сарын 16-ны өдөр)
5. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай (2014 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр)
6. Гамшгаас хамгаалах тухай /Шинэчилсэн найруулга/ (2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр)
7. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай (2010 оны 06 дугаар сарын 10-ны өдөр)
8. Гаалийн тухай хууль (2008 оны 05 дугаар сарын 20-ны өдөр)
9. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай /Шинэчилсэн найруулга/ (2019 оны 06 дугаар сарын 06-ний өдөр)
10. Дархлаажуулалтын тухай (2000 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр)
11. Донорын тухай /Шинэчилсэн найруулга/ (2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр)
12. Зар сурталчилгааны тухай (2002 оны 05 дугаар сарын 30-ны өдөр)
13. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай (2004 оны 02 дугаар сарын 15-ны өдөр)
14. Захиргааны ерөнхий хууль (2015 оны 06 дугаар сарын 19-ний өдөр)
15. Зөвшөөрлийн тухай /Шинэчилсэн найруулга/ (2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр)
16. Зөрчил шалган шийдвэрлэх тухай (2017 оны 05 дугаар сарын 18-ны өдөр)
17. Зөрчлийн тухай /Шинэчилсэн найруулга/ (2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр)
18. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай (1995 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр)
19. Иргэний хууль (2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр)
20. Кибер аюулгүй байдлын тухай хууль (2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр)
21. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай (2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр)
22. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр)
23. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай (2011 оны 05 дугаар сарын 26-ны өдөр)
24. Монгол улсын Засгийн газрын тухай (1993 оны 05 дугаар сарын 06-ны өдөр)
25. Монгол Улсын Үндсэн хууль (1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр)
26. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай (2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр)
27. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ (2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр)
28. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай (2017 оны 12 дугаар сарын 21-ний өдөр)
29. Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ (2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр)
30. Төрийн болон албаны нууцын тухай (2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр)
31. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай (2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр)
32. Төрийн хяналт, шалгалтын тухай (2003 оны 12 дугаар сарын 27-ны өдөр)

33. Төсвийн тухай хууль (2011 оны 12 дугаар сарын 23-ны өдөр)
34. Төрийн хэмнэлтийн тухай хууль (2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр)
35. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль (2010 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр)
36. Үндэсний аюулгүй байдлын тухай (2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр)
37. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ (2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр)
38. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай (2008 оны 05 дугаар сарын 22-ны өдөр)
39. Хөдөлмөрийн тухай /Шинэчилсэн найруулга/ (2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр)
40. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай /Шинэчилсэн найруулга/ (2021 оны 12 дүгээр сарын 17-ны өдөр)
41. Хэмжил зүйн тухай хууль (2019 оны 05 дугаар сарын 09-ний өдөр)
42. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай (2010 оны 05 дугаар сарын 27-ны өдөр)
43. Эрүүл мэндийн тухай хууль (2011 оны 05 дүгээр сарын 05-ний өдөр)
44. Эрүүл мэндийн даатгалын тухай (2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр)

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ:

1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенц (1990 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр)
2. Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц (1961 оны 03 дугаар сарын 25-ны өдөр)
3. Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц (1971 оны 02 дугаар сарын 21-ний өдөр)

УИХ-ЫН ТОГТООЛ:

1. “АЛСЫН ХАРАА-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого
2. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай
3. Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
4. Төрөөс эмийн талаар баримтлах бодлого (2014 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 57 дугаар тогтоол)

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

1. Агентлаг байгуулах тухай – Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар (2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 222 дугаар тогтоол)
2. Агентлагын байгуулах тухай–Засгийн газрын 2020 оны 222 дугаар тогтоол, тогтоолын хавсралтанд өөрчлөлт оруулах тухай (2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 378 дугаар тогтоол)
3. Дүрэм батлах тухай – Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм (2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоол)
4. Журам батлах тухай – Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам (2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 246 дугаар тогтоол)
5. Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай (Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 388 дугаар тогтоол)
6. Журам шинэчлэн батлах тухай – Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам (2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 217 дугаар тогтоол)
7. Журам шинэчлэн батлах тухай – Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам (2020 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 206 дугаар тогтоол)
8. Журам шинэчлэн батлах тухай – Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам (2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 216 дугаар тогтоол)
9. “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай (Шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт

бодисын жагсаалт) (2003 оны 196 дугаар тогтоол)

10. Нийтлэг журам батлах тухай – ААНБ-ын дотоод хяналт шалгалт (2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 311 дүгээр тогтоол)
11. Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам (2002 оны 219 дүгээр тогтоол)
12. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам (2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 218 дугаар тогтоол)
13. Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомтыг тогтоох тухай (2011 оны 73 дугаар тогтоол)

САЙДЫН ТУШААЛ:

1. Амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг зохицуулах журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2009 оны 388 дугаар тушаал)
2. Бүртгэлийн болон GMP-ын шинжээч ажиллуулах журам батлах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 225 дугаар тушаал)
3. Гадаад, дотоодын эм үйлдвэрлэгчийн төлөөлөгчийн газрын ажиллах журам (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 284 дугаар тушаал)
4. Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийг бүртгэн мэдээлэх, тандах журамд өөрчлөлт оруулах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны А/278 дугаар тушаал)
5. Зайлшгүй шаардлагатай эмийн 9 дэх, Хүүхдийн зайлшгүй шаардлагатай эмийн 2 дах жагсаалт шинэчлэн батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/625 дугаар тушаал)
6. Монгол улсын хүн амын эмчилгээнд хэрэглэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалт батлах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны А/184 дүгээр тушаал)
7. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам батлах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 68 дугаар тушаал)
8. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай (Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/28 дугаар тушаал)
9. Монгол улсын үндэсний фармакопайд өөрчлөлт оруулах тухай (Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/219 дугаар тушаал)
10. Өнчин эмийн жагсаалт батлах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 271 дүгээр тушаал)
11. Өнчин эмийн жагсаалтад нэмэлт оруулах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны А/30 дугаар тушаал)
12. Өнчин эмийн жагсаалтад нэмэлт оруулах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2017 оны А/301 дугаар тушаал)
13. Тусламж, хандиваар эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх, хүлээн авах, хэрэглэх журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/232 дугаар тушаал)
14. Үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай (Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн эрүүл мэндийн салбарт хэрэгжих үйл ажиллагааны төлөвлөгөө (Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/289 дугаар тушаал)
15. Фармакопей боловсруулах, батлах, дугаар өгөх, фармакопейн хорооны бүрэлдэхүүн, ажиллах журам шинэчлэн батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2014 оны 132 дугаар тушаал)
16. Хлорт фторт нүүрстөрөгч агуулсан ингаляци хэлбэрийн эмийн бүртгэлийг зогсоох тухай (Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2009 оны 217/259 дүгээр тушаал)
17. Хүний эмийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 30 дугаар тушаал)
18. Хүний эмийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/144 дугаар тушаал)

19. Хэмжил зүйн ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах (Монгол Улсын Шадар сайдын 2015 оны 117 дугаар тушаал)
20. Цахимаар эмийн жор бичих, олгох заавар батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/495 дугаар тушаал)
21. Шалгалт баталгаажуулалтад хамруулах хэмжих, хэрэгслийн жагсаалт (Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 125 дугаар тушаал)
22. Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2011 оны 297 дугаар тушаал)
23. Эмийн гаж нөлөө болон аюулгүй байдлын мэдээллийг бүртгэн, мэдээлэх журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2013 оны 415 дугаар тушаал)
24. Эмийн зах зээлийн дараах тандалт судалгаа хийх журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2014 оны 33 дугаар тушаал)
25. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 дугаар тушаал)
26. “Эмнэл зүйн туршилт явуулах, судалгаа, шинжилгээний зорилгоор хүний цус, цусан бүтээгдэхүүн, биологийн шингэн, эд, эрхтэн авах, хэрэглэх журам” (Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/526 дугаар тушаал)
27. Эм зүйн салбарын сайн засаглалын удирдамж батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/190 дүгээр тушаал)
28. Эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдлын программыг нэвтрүүлэх журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/19 дүгээр тушаал)
29. Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын лиценз олгох журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/407 дүгээр тушаал)
30. Эмнэлгийн эм зүйн албаны үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрэм батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/180 дүгээр тушаал)
31. Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх журам батлах (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 249 дүгээр тушаал)
32. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам (ЭМС-ын 2017 оны А/493 дугаар тушаал)
33. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх журам (ЭМС-ын 2018 оны А/344 дүгээр тушаал)
34. Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх арга аргачлал (ЭМС-ын 2018 оны А/345 дугаар тушаал)
35. Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх арга аргачлал (ЭМС-ын 2021 оны А/464 дүгээр тушаал)
36. Эмийн эмчилгээг зохицуулах хорооны ажиллах журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/414 дүгээр тушаал)
37. Эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг бүртгэх журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/295 дугаар тушаал)
38. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2017 оны 505 дугаар тушаал)
39. Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага (Эрүүл мэндийн сайдын 2013 оны 145 дугаар тушаал)
40. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс ажиллах тухай журам шинэчлэн батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/400 дугаар тушаал)
41. Төлбөрийг нь төр хариуцах эмийн санхүүжилтийг тооцох, эрүүл мэндийн даатгалын сангаас

санхүүжүүлэх журам (Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоолын тавдугаар хавсралт)

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ:

1. Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP/-ын батламж олгох журам батлах тухай (ЭЭХХЗГ-ын даргын 2021 оны А/168 дугаар тушаал)
2. Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP/-ын шинжээч сонгон шалгаруулах, ажиллуулах журам батлах тухай (ЭЭХХЗГ-ын даргын 2022 оны А/236 дугаар тушаал)
3. Эм, эмнэлгийн хэрэгсэл, Биологийн идэвхт бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын талаар эрт сэрэмжлүүлэх түүнийг эргүүлэн татах журам батлах тухай (ЭЭХХЗГ-ын даргын 2022 оны А/237 дугаар тушаал)
4. Эм, Биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны зөвшөөрөл олгох үйл ажиллагааны журам батлах тухай (ЭЭХХЗГ-ын даргын 2022 оны А/236 дугаар тушаал)

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ:

1. Биологийн идэвхт бүтээгдэхүүн ханган нийлүүлэх байгууллагад тавих шаардлага MNS 6396:2013
2. Биобэлдмэлийн үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага. MNS 5524-2:2014
3. Уламжлалт эмийн үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага. MNS 5524-3:2015
4. Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага MNS/ISO 17025
5. Фармакопейн өгүүлэл боловсруулах арга зүй. MNS 5763:2015
6. Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага. MNS 5530:2014
7. Эмийн идэвхт бодис ба эмийн тогтвортой чанарын судалгаанд тавих ерөнхий шаардлага. MNS 6439:2014
8. Эм үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага. MNS 5524-1:2014
9. Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага. MNS 5260:2015
10. Эмийн анхдагч савлалтын материалд тавих ерөнхий шаардлага. MNS 6622-2016
11. Эмийн жорын маягт, жор бичилтийн стандарт MNS 5376:2016
12. Эмийн чанарын хяналтын лабораторид тавих шаардлага. MNS 6621-2016
13. Эмнэлгийн цахилгаан тоног, төхөөрөмж, 2-25-р хэсэг: Зүрхний цахилгаан бичлэгийн аппаратын үндсэн үзүүлэлт, аюулгүй ажиллагаанд тавих шаардлага MNS/IEC 60601-2-25:2019
14. Эмнэлгийн цахилгаан тоног төхөөрөмж. Эмнэлгийн цахилгаан тоног төхөөрөмжийн ээлжит болон засварын дараах туршилт MNS IEC 62353:2019

ДЭМБ-ЫН ЗОХИСТОЙ ДАДЛЫН СТАНДАРТЫН БАРИМТ БИЧИГ:

1. Эмийн хяналтын лабораторийн зохистой дадал-GLP WHO Technical Report Series, No.957, 2010, Annex 1
2. Эмийн үйлдвэрийн зохистой дадал Good Manufacturing Practices for Pharmaceutical products: WHO Technical Report Series No.961 2011, Annex 3
3. Эмийн микробиологийн лабораторийн зохистой дадал GLP, WHO Technical Report Series, No.961, 2011, Annex 2

2.2. ЭМ ХАНГАМЖИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЗҮҮЛЭЛТ

Эм хангамжийн байгууллагын үзүүлэлтийг дараах чиглэлээр гаргав.

1. Эм, эмнэлгийн хэрэгсэл, протез, биологийн идэвхт бүтээгдэхүүний үйлдвэр
2. Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага
3. Эмийн сан

2022 онд нийт 3130 эм хангамжийн байгууллага үйл ажиллагаа явуулснаас эм, эмнэлгийн хэрэгсэл, протез, биологийн идэвхт бүтээгдэхүүний үйлдвэр 40, ханган нийлүүлэх байгууллага 495, эмийн сан 2595 байна.(Хүснэгт 2.)


Хүснэгт 2. Эм хангамжийн байгууллагын тоо, 2018-2022он

№	Эм хангамжийн байгууллагын төрөл	2018 он		2019 он		2020 он		2021 он		2022 он	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Үйлдвэр	41	1.6%	59	2.4%	38	1.4%	43	1.5%	40	1.4%
2	Ханган нийлүүлэх байгууллага	360	14.2%	357	14.7%	384	13.9%	444	15.7%	495	13.9%
3	Эмийн сан	2128	84.1%	2015	82.9%	2343	84.7%	2335	82.8%	2595	84.7%
Нийт		2529	100%	2431	100%	2765	100%	2822	100%	3130	100%

2.2.1. ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ҮЙЛДВЭР

2022 онд үйлдвэрлэлийн чиглэлээр 40, ханган нийлүүлэх чиглэлээр 495 байгууллага /давхардсан тоогоор/ үйл ажиллагаа явуулсан байна. (Зураг 6.)

Зураг 6. Үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллагын тоо, 2018-2022 он




Улсын хэмжээнд 2022 онд нийт эм, эмнэлгийн хэрэгсэл, Биологийн идэвхт бүтээгдэхүүн, ариутгал, халдваргүйтгэлийн бодис үйлдвэрлэх 40 үйлдвэрийн 25 нь эмийн үйлдвэр байгаагаас эм үйлдвэрлэлийн зохистой дадал” GMP-ийн (үйлдвэрлэлийн зохистой дадал) шаардлага хангасан 9 үйлдвэр байна.

Тавин-Ус, Мон-Интра компануудын эмийн үйлдвэр 2022 онд үйлдвэрлэлийн зохистой дадлын /GMP-ийн/ шаардлага хангаж батламж авсан.


2022 онд тусгай зөвшөөрөлтэй үндэсний 40 үйлдвэр нь эм, эмнэлгийн хэрэгсэл, протез, биологийн идэвхт бүтээгдэхүүн, ариутгал, халдваргүйтгэлийн бодис үйлдвэрлэх чиглэлээр (давхардаагүй нийт 57) үйл ажиллагаа явуулсан байна. (Зураг 7.)

Зураг 7. Үйлдвэрийн үйл ажиллагааны чиглэлээр, 2022 он



2022 онд эмийн үйлдвэрийн тусгай зөвшөөрөлтэй 25 үйлдвэр нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. (Зураг 8.)


Зураг 8. Эмийн үйлдвэрийн үйл ажиллагааны чиглэлээр, 2022 он



2.2.2. ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА

2022 оны байдлаар нийт тусгай зөвшөөрөлтэй 495 ханган нийлүүлэх байгууллагууд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулсан байна. /давхардсан тоогоор/ (Зураг 9.)

Зураг 9. Ханган нийлүүлэх байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр, 2022 он



2.2.3. ЭМИЙН САН


Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага MNS 5260:2015 стандартын дагуу нийтийн үйлчилгээтэй эмийн сан, эмнэлгийн эмийн сан гэж ангилна.

1. Нийтийн үйлчилгээтэй эмийн санг зэрэглэлээр дараах байдлаар ангилна.
 - 1.1. Нэгдүгээр зэрэглэлийн эмийн сан
 - 1.2. Хоёрдугаар зэрэглэлийн эмийн сан

Улсын хэмжээнд 2022 онд нийт 2595 эмийн сан үйл ажиллагаа явуулснаас нэгдүгээр зэрэглэлийн 268 (эмийн сангийн 10.4%), хоёрдугаар зэрэглэлийн 2178 (83.9%), эргэлтийн эмийн сан 149 (5.7%) тус тус эзэлж байна.

Эмийн санг байршлаар нь ангилбал Улаанбаатар хотод 1492 (57.5%), орон нутагт 1103 (42.5%) эмийн сан үйл ажиллагаа явуулжээ. Үүнээс Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа нийт эмийн сангаас нэгдүгээр зэрэглэлийн 121 (8.1%), хоёрдугаар зэрэглэлийн 1371 (91.8%) эмийн сан тус тус ажилласан байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа нийт эмийн сангаас нэгдүгээр зэрэглэлийн 147 (13.3%), хоёрдугаар зэрэглэлийн 956 (86.7%) эмийн сан тус тус үйл ажиллагаа явуулсан. (Зураг 10.)

Зураг 10. Эмийн сангийн тоо, байршил, зэрэглэлээр, 2022 он



Хүснэгт 3. Эмийн сангийн тоо байршлаар, 2018-2022 он

№	Аймаг, хотын нэр	I Зэрэглэлийн эмийн сангийн тоо					II зэрэглэлийн эмийн сангийн тоо					Эргэлтийн эмийн сан		2022 он нийт
		2018	2019	2020	2021	2022	2018	2019	2020	2021	2022	Сумын	Хувийн	
												2022	2022	
1	Архангай	4	4	4	4	4	39	54	54	38	40	-	18	62
2	Баян-Өлгий	2	2	2	2	2	27	37	37	35	44	14	-	60
3	Баянхонгор	6	7	10	11	10	15	14	13	35	21	-	19	50
4	Булган	2	3	3	2	-	19	35	24	27	27	-	13	40
5	Говь-Алтай	1	-	1	2	-	14	31	12	14	19	-	19	37
6	Говьсүмбэр	-	-	-	-	-	10	10	7	10	11	-	-	11
7	Дархан-Уул	8	10	7	6	8	52	48	53	57	59	-	-	67
8	Дорноговь	11	11	10	10	10	16	17	15	20	25	-	14	49
9	Дорнод	9	8	11	11	11	24	18	22	27	27	13		51
10	Дундговь	3	4	5	5	5	6	7	7	7	7	14		26
11	Завхан	4	2	2	2	2	21	26	24	27	23		21	46
12	Орхон	36	39	48	50	58	21	19	18	27	27	-	-	85
13	Өвөрхангай	5	4	4	3	3	30	55	55	45	53	-	18	74
14	Өмнөговь	3	2	2	2	2	24	28	30	46	44	13	-	59
15	Сүхбаатар	3	3	4	4	4	13	12	10	11	13	12	-	29
16	Сэлэнгэ	9	9	9	7	8	35	47	26	26	40	20	-	68
17	Төв	1	-	-	-	-	29	29	29	33	34	26	-	60
18	Увс	9	7	6	6	3	13	20	21	28	44	18	-	65
19	Ховд	12	11	11	11	12	12	14	14	29	16	16	-	44
20	Хөвсгөл	2	2	2	2	2	46	45	49	50	48		23	73
21	Хэнтий	4	4	4	1	3	24	24	24	29	24	3	17	47
	Орон нутгийн хэмжээнд	134	135	145	141	147	490	594	544	621	646	149	162	1103
	Улаанбаатарт	190	129	89	76	121	914	1075	1254	1249	1371	-	-	1492

Хүснэгт 4. Үйл ажиллагаа явуулсан эмийн сангийн тоо, бүс нутгаар 2022 он

№	Аймаг хотын нэр	I зэрэглэлийн хувийн эмийн сангийн тоо	II зэрэглэлийн эмийн сангийн тоо		Нийт
		2022 он	Хувийн	Эргэлтийн	
		2022 он	2022 он	2022 он	2022 он
Баруун бүс					
1	Баян-Өлгий	2	44	14	60
2	Говь-Алтай	-	37	-	37
3	Завхан	2	44	-	46
4	Увс	3	44	18	65
5	Ховд	12	16	16	44
Хангайн бүс					
1	Архангай	4	58	-	62
2	Баянхонгор	10	40	-	50
3	Булган	-	40	-	40
4	Орхон	58	27	-	85
5	Өвөрхангай	3	71	-	74
6	Хөвсгөл	2	71	-	73
Төвийн бүс					
1	Говьсүмбэр	-	11	-	11
2	Дархан-Уул	8	60	-	67
3	Дорноговь	10	39	-	49
4	Дундговь	5	7	14	26
5	Өмнөговь	2	44	13	59
6	Сэлэнгэ	8	40	20	68
7	Төв	-	34	26	60
Зүүн бүс					
1	Дорнод	11	27	13	51
2	Сүхбаатар	4	13	12	29
3	Хэнтий	3	41	3	47
Орон нутгийн хэмжээнд		147	807	149	1103
Улаанбаатар		121	1371	-	1492
Улсын хэмжээнд		268	2178	149	2595

Зураг 11. Эмийн сангийн тоо, байршлаар, 2022



2022 онд нийслэлд 108, орон нутагт 126 тусгай зөвшөөрөл, нийт улсын хэмжээнд 234 эмийн санд тусгай зөвшөөрөл шинээр олгосон байна.

2.3. ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Улсын хэмжээнд 2022 оны байдлаар төрийн захиргаа болон төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага, эм хангамжийн байгууллагад нийт 3822 эм зүйч, 2218 эм найруулагч ажиллаж байна. Өмнөх онтой харьцуулахад

нийт эм зүйчийн тоо 844-ээр буюу 28%-иар, эм найруулагчийн тоо 208-аар буюу 10%-иар тус тус нэмэгдсэн байна. (Хүснэгт 5.)

Хүснэгт 5. Эм зүйч, эм найруулагчийн тоо, тусламж үйлчилгээний шатлалаар, 2019-2022

Эрүүл мэндийн байгууллагууд		Эм зүйч				Эм найруулагч			
Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагууд		2019 он	2020 он	2021 он	2022 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Багийн эмчийн салбар		0	0	0	0	0	0	1	1
Өрхийн эрүүл мэндийн төв		0	0	0	1	0	0	0	0
Тосгоны эрүүл мэндийн төв		0	1	0	1	4	5	3	10
Сумын эрүүл мэндийн төв	А зэрэглэл	8	9	15	24	24	27	25	27
	Б зэрэглэл	13	13	16	53	53	52	51	46
	В зэрэглэл	16	15	16	70	70	61	65	62
Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг		5	6	4	6	7	8	7	7
Аймгийн нэгдсэн эмнэлэг		31	31	32	36	43	38	43	39
Дүүргийн нэгдсэн эмнэлэг		15	18	18	18	6	6	9	6
Аймгийн нийгмийн эрүүл мэндийн төв		0	0	0	0	0	0	0	0
Дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв, НЭМҮТ		22	23	25	31	15	13	8	12
Бүсийн оношилгоо эмчилгээний төв		22	22	25	26	8	6	4	6
Тусгай мэргэжлийн төв		0	0	0	0	0	0	0	0
Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг		97	103	114	118	23	20	17	18
Амаржих газар		9	10	10	10	3	2	2	1
Түргэн тусламжийн төв		1	1	1	1	11	11	11	12
Сэргээн засах төв		1	0	0	0	1	0	0	0
Клиник/ улсын/		0	0	0	0	0	0	0	0
Клиник /Хувийн/		13	22	22	26	0	10	6	12
Ортой хувийн эмнэлэг		73	75	89	103	31	27	35	36
Сувилал		2	2	1	1	0	2	3	0
Хөнгөвчлөх асаргаа, сувилгааны төв		0	1	3	6	0	0	1	1
Сувилгахуйн төв		0	0	0	0	0	0	0	0
ЭМЯ, ЭМХТ		0	0	0	0	0	0	0	0
ЭЭХХЗГ		-	-	65	65	-	-	-	-
Эрүүл мэндийн газар (аймаг, нийслэл)		11	11	8	7	4	4	2	3
Эм ханган нийлүүлэх байгууллага		137	117	135	373	159	137	117	164
Эмийн үйлдвэр		6	0	0	3	12	0	0	0
Эмийн сан / хувийн/		1983	2112	2332	2887	1400	1556	1577	1729
Бусад		4	5	5	8	6	7	7	6
Бүгд (Эрүүл мэндийн салбарт)		2469	2597	2936	3874	1880	1992	1994	2198
Тусгай эмнэлэг		11	12	17	19	15	12	8	11
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харьяа эрүүл мэндийн байгууллага		9	15	11	16	3	3	6	5
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа эрүүл мэндийн байгууллагууд		2	2	1	1	0	1	0	1
Төмөр замын нэгдсэн эмнэлэг		7	7	5	7	1	1	1	1
Бусад (уурхай, үйлдвэр, албан газар, мэргэжлийн хяналтын газар гэх мэт)		11	6	8	5	0	0	1	2
Бүгд (Бусад салбарт)		40	42	42	48	19	17	16	20
Бүгд		2509	2639	2978	3822	1899	2009	2010	2218

Эх үүсвэр: Эрүүл мэндийн хөгжлийн төв, Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн тайлан-2022 он
2022 оны байдлаар орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад 1117 эм зүйч, 1211 эм найруулагч, 57 эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, Улаанбаатарт 2645 эмзүйч, 2218 эм найруулагч, 199 эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер тус тус ажиллаж байна. 2021 оны үзүүлэлттэй харьцуулахад орон нутгийн эрүүл мэндийн салбарт ажиллах эм зүйчийн тоо 117-оор, эм найруулагчийн тоо 16-аар, эмнэлгийн төхөөрөмжийн инженерийн тоо 5-аар тус тус нэмэгдсэн байна.


Улсын хэмжээнд хөдөө орон нутаг, улаанбаатар хотод эрүүл мэндийн салбарт ажилласан эм зүйч, эм найруулагч, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерийн тоог байршлаар харуулав. (Хүснэгт 6.)

Хүснэгт 6. Эм зүйч, эм найруулагч, ЭТТИ-ийн тоо, аймаг нийслэлд, 2021-2022 он

№	Аймаг	Эм зүйч		Эм найруулагч		Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер	
Улсын дундаж		2021 он	2022 он	2021 он	2022 он	2021 он	2022 он
		3822		2218			
Баруун бүс							
1	Баян-Өлгий	63	73	72	83	3	3
2	Говь-Алтай	31	38	60	62	2	2
3	Завхан	31	38	41	42	3	3
4	Увс	57	74	43	43	3	3
5	Ховд	57	72	59	59	2	3
Хангайн бүс							
1	Архангай	41	57	64	62	1	1
2	Баянхонгор	44	52	60	57	1	1
3	Булган	29	32	41	37	2	3
4	Орхон	113	162	98	113	4	10
5	Өвөрхангай	40	46	51	51	9	8
6	Хөвсгөл	53	58	77	84	4	4
Төвийн бүс							
1	Говьсүмбэр	12	10	11	10	0	0
2	Дархан-Уул	84	90	112	114	4	2
3	Дорноговь	52	50	78	75	3	1
4	Дундговь	27	27	23	20	1	1
5	Өмнөговь	51	70	59	55	3	3
6	Сэлэнгэ	27	36	84	88	2	1
7	Төв	30	29	36	38	1	2
Зүүн бүс							
1	Дорнод	49	49	35	35	2	4
2	Сүхбаатар	19	20	37	34	1	0
3	Хэнтий	30	34	54	49	2	2
Орон нутагт		940	1117	1195	1211	52	57
Улаанбаатар		1973	2705	815	1007	162	199
Бүгд		2913	3822	2010	2218	215	256

Улсын болон хувийн хэвшлийн их, дээд сургууль, коллежид эм зүйч, эм найруулагч мэргэжлээр төгсгөгч бэлтгэн гаргаж байна. 2022 онд нийт 611 эм зүйч, 157 эм найруулагч мэргэжлээр төгссөн. 2021 онтой харьцуулахад эм зүйчээр төгсөгчдийн тоо 65-аар буурч, эм найруулагч мэргэжлээр төгсөгчдийн тоо 47-иар нэмэгдсэн байна. (Зураг 12.)

Зураг 12. Эм зүйч, эм найруулагч мэргэжлээр төгсөгчдийн тоо, 2015-2022 он




2022 онд АШУУИС-ийн Эм зүйн сургууль 108, ЭЗШУИС 251, Этүгэн их сургууль 86, ШАУИС 70, Энэрэл Дээд сургууль 96, Оточ манрамба дээд сургууль 7 төгсөгч эм зүйч мэргэжлээр, АШУУИС-ийн Эм зүйн сургуулийг 35, Говь-Алтайн АУК-ийг 31, Дарханы АУК-ийг 28, Дорноговийн АУК-ийг 10 төгсөгч эм найруулагч мэргэжлээр тус тус төгссөн байна. (Хүснэгт 7.)

Хүснэгт 7. Эм зүйч /бакалавр/ төгсөгчдийн тоо сургуулиар, 2018-2022 он

№	Сургуулийн нэр	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
		Эм зүйч /бакалавр/				
1	АШУУИС-Эмзүйн сургууль	94	116	83	81	108
2	ЭЗШУИС (Монос)	125	126	145	249	251
3	Этүгэн Их сургууль	60	93	78	158	86
4	ШАУИС	116	116	95	70	70
5	Энэрэл дээд сургууль	-	-	-	86	96
6	Оточ манрамба их сургууль	-	-	-	7	-
7	МУИС	-	-	-	25	-
Нийт		395	451	401	676	611

Зураг 13. Эм найруулагч мэргэжлээр төгсөгчдийн тоо, 2018-2022 он



Улсын хэмжээнд эм зүйч болон эм найруулагч мэргэжлээр улсын болон хувийн хэвшлийн 10 их дээд сургууль боловсон хүчинг сурган төгсгөж байна.

2022 оны байдлаар улсын хэмжээнд нийт эм зүйч мэргэжлээр 5126, эм найруулагч мэргэжлээр 4968 / давхардсан/ төгсөгч төгссөн байна.

Харин эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер мэргэжлээр ШУТИС-ийн Эрчим хүчний сургууль 2002 оноос анх бэлдэж эхэлсэн ба ШУТИС-Эрчим хүчний сургууль, Хүрээ мэдээлэл холбоо, технологийн дээд сургууль, Этүгэн Их сургуулиуд бэлдэж байна. 2022 оны байдлаар 963 төгсөгчийг бэлтгэн сургаж төгсгөжээ. (Хүснэгт 8.)

Хүснэгт 8. Нийт эм зүйч, эм найруулагч, ЭТТИ мэргэжлээр /бакалавр/ төгсөгчдийн тоо, 2022 оны байдлаар

№	Сургууль	Эм зүйч	Эм найруулагч	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер
1	ЭЗШУИС	1997	88	-
2	Этүгэн ИС	937	-	236
3	Энэрэл ДС	18	7	62
4	ШАУИС	492	-	-
5	Оточ манранба ИС	21	-	-
6	МУИС	25	-	-
7	АШУУИС-Эм зүйн сургууль	1636	3183	-
8	АШУУИС-Говь Алтайн АУК	-	598	-
9	АШУУИС-Дорноговь АУК	-	502	-
10	АШУУИС-Дархан АУК	-	890	-
11	ШУТИС	-	-	540
12	Хүрээ ДС	-	-	125
13	Нийт төгсөгчдийн тоо	5126	4878	963


Улсын хэмжээнд 2022 оны байдлаар нийт бэлтгэгдсэн эм зүйчдийн 320 нь магистр зэрэгтэй, 69 доктор зэрэгтэй байна. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер мэргэжлээр бэлтгэгдсэн инженерүүдийн 68 магистр зэрэгтэй, 16 доктор зэрэгтэй байна.

2.4. ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2.4.1. ЭМИЙН САНХҮҮЖИЛТ

Эрүүл мэндийн салбарын төсөв 2022 онд 1.48 их наяд төгрөг болсон нь өмнөх онтой харьцуулахад 162.3 тэрбум төгрөгөөр буюу 9.9%-иар буурч, эм, эмнэлгийн хэрэгслийн төсөв 439.6 тэрбум төгрөг болсон нь өмнөх онтой харьцуулахад 102.8 тэрбум төгрөгөөр буюу 19%-иар буурсан байна. (Зураг 14.)

Зураг 14. Эрүүл мэндийн төсөв, тэрбум төгрөгөөр, 2012-2022 он




Эх үүсвэр: Эрүүл Мэндийн яам, Санхүүгийн тайлан 2022 он

Улсын хэмжээнд 2022 онд нийслэлд 848, орон нутагт 907, нийт 1755 эмийн сан Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээтэй ажилласан ба 574 нэрийн эмэнд 81.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон байна.

2021 онтой харьцуулахад эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон эмийн санхүүжилтийн хэмжээ 11.8 тэрбум буюу 17.0 хувиар нэмэгдсэн байна. (Зураг 15.)

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон эмийн санхүүжилт нь сүүлийн 5 жилийн байдлаар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 15. ЭМД-ын сангаас олгосон эмийн үнийн хөнгөлөлт, тэрбум төгрөгөөр, 2016-2022 он




Эх үүсвэр: Эрүүл Мэндийн Даатгалын ерөнхий газар, Үйл ажиллагааны тайлан 2022 он

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн “Эмийн жагсаалт шинэчлэн батлах тухай” 11 дүгээр тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-г шинэчлэн баталж, мөрдөж эхэлсэн. Жагсаалтад багтсан 159 ерөнхий нэршлийн 574 худалдааны нэрийн эмийг эрүүл мэндийн даатгалын сангаас 30-70 хүртэл хувийн үнийн хөнгөлөлт олгож, гэрээ бүхий эмийн сангуудад эмийн үнийн хөнгөлөлтийн санхүүжилт олгосон байна.

Амбулаториор эмчлэх өвчний жагсаалтад тусгагдсан саажилт, уналт таталттай хүүхдийн уналт таталтын эсрэг эмийн үнийн хөнгөлөлтийг хүүхдэд /0-19 нас хүртэлх/ Эрүүл Мэндийн Даатгалын Сангаас 100 хувиар хөнгөлөлт олгож байна. Эрүүл Мэндийн Даатгалын Сангаас хамгийн их хөнгөлөлт олгосон 10 нэрийн эмийг жагсаалтаар харуулав. (Зураг 16.)

Зураг 16. ЭМД-ын сангаас хөнгөлөлтөөр хамгийн их олгосон 10 нэрийн эм, мөнгөн дүнгээр, 2022 он



2022 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас Урсофальк 250мг шахмалд 5,117,391 тэрбум төгрөг, Клопиденк 75мг шахмалд 4,266,534 тэрбум төгрөг, Брайн-акт 500мг шахмалд 4,124,358 тэрбум төгрөг, Экватор 10мг+20мг шахмалд 4,068,928 тэрбум төгрөг эмүүдэд тус тус олгожээ.

2.4.2. ЭМИЙН ИМПОРТ


2022 онд Монгол улсад бүртгэлтэй байгаа 51 улсын 1724 (худалдааны нэршилээр) нэр төрлийн эмийг импортолсон. 2021 онтой харьцуулахад импортолсон эмийн тоо 105-аар (худалдааны нэршилээр) нэмэгдсэн байна. (Хүснэгт 9.)

Хүснэгт 9. Импортолсон эмийн тоогоор, 2021-2022 он

Он	Эмийн төрөл	Эмийн тоо (Олон улсын нэршилээр)	Эмийн тоо (Худалдааны нэршилээр)	Импортолсон улсын тоо (давхардсан тоогоор)	Үйлдвэрлэгчийн тоо (давхардсан тоогоор)
2021	НИЙТ	839	1619	49	492
Үүнээс	Биобэлдмэл	25	41	9	20
	Антибиотик	82	235	30	120
	Уламжлалт эм	4	30	5	7
	Бусад төрлийн эм	728	1313	51	419
2022	НИЙТ	916	1724	51	514
Үүнээс	Биобэлдмэл	14	23	10	15
	Антибиотик	79	226	30	107
	Уламжлалт эм	3	25	4	8
	Бусад төрлийн эм	820	1470	51	458

Импортолсон эмийг олон улсын АТС ангилалаар ангилж авч үзвэл А ангилал буюу хоол боловсруулах замын эмгэгт хэрэглэх эм (356 нэр төрөл), J ангилал буюу нянгийн эсрэг хэрэглэх эм (301 нэр төрөл), R ангилал буюу амьсгалын тогтолцооны эмгэгт хэрэглэх эмийг (258 нэр төрөл) голчлон импортолсон байна. (Зураг 17.)

Зураг 17. Импортолсон эмийн тоо, АТС кодоор, 2022 он




2022 онд эм ханган нийлүүлэх байгууллагууд эм үйлдвэрлэлээрээ тэргүүлдэг 6 улсын /БНСУ, БНЭУ, Франц, Швейцарь, Герман, БНХАУ/ эмийн компаниас голчлон импорт хийсэн. Шинээр АНЭУ, Бангладеш, БНАСАУ, Исланд 4 улсаас импорт хийгдсэн байна. Харин өмнөх онуудад импорт хийгдэж байсан Куба болон Мексик улсаас импорт хийгдээгүй байна.

2021-2022 онд хамгийн их мөнгөн дүнгээр импорт хийгдсэн улс бол БНСУ, БНЭУ, Герман, ОХУ, Швед, Словени,


Франц, Швейцарь байна. Хамгийн бага мөнгөн дүнгээр импорт хийгдсэн улс Хорват, Хойд македон, Мексик, Австрали, Аргентин, Серби, Молдав, Куба, Казакстан, Бразил байна. (Зураг 18.)

Зураг 18. Хамгийн их эмийн импорт хийсэн улс, эзлэх хувиар, 2021-2022 он



2022 онд эмийн 638 тэрбум төгрөгийн импорт, 548.9 тэрбум төгрөгийн борлуулалт (бөөний үнээр) хийсэн нь 2021 онтой харьцуулахад эмийн импорт 151.5 тэрбум төгрөг буюу 30%-иар, эмийн борлуулалт 117.9 тэрбум төгрөг буюу 27%-иар тус тус өссөн байна. (Зураг 19.)


Зураг 19. Эмийн импорт, борлуулалт, тэрбум төгрөгөөр, 2015-2022 он



2.4.3. ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ИМПОРТ

2022 онд 108.7 тэрбум төгрөгийн эмнэлгийн хэрэгслийн импорт, 87.5 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь 2021 онтой харьцуулахад импорт 12.7, борлуулалт 20.1 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна. (Зураг 20.)

Зураг 20. Эмнэлгийн хэрэгсэл, протезын импорт, борлуулалт, тэрбум төгрөгөөр 2015-2022 он



2.4.4. УРВАЛЖ, СТАНДАРТ БОДИСЫН ИМПОРТ

2022 онд нийт 40.4 тэрбум төгрөгийн урвалж, стандарт бодис импортолж, 29.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь 2021 онтой харьцуулахад импорт нь 3.4, борлуулалт нь 8.9 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна. (Зураг 21.)


Зураг 21. Урвалж, стандарт бодисын импорт, борлуулалт, тэрбум төгрөгөөр, 2015-2022 он



2.4.5. ОНОШЛУУРЫН ИМПОРТ


2022 онд нийт 37.6 тэрбум төгрөгийн оношлуур импортолж, 34.3 тэрбум төгрөг борлуулалт хийсэн нь 2021 онтой харьцуулахад импорт 30.7, борлуулалт 25.4 тэрбум төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна. (Зураг 22.)

Зураг 22. Оношлуурын импорт, борлуулалт, тэрбум төгрөгөөр, 2015-2022 он



2.4.6. ИМПОРТЫН ЛИЦЕНЗ


Зураг 23. Олгосон импортын лиценз болон байгууллагын тоо, 2021-2022 он



2022 онд 329 байгууллагад 8722 импортын лицензийг олгосон байна. Өмнөх онтой харьцуулахад лиценз олгосон байгууллагын тоо 8-аар, олгосон лицензийн тоо 135-аар буурсан байна. (Зураг 23.)

Олгосон импортын лицензийг сараар авч үзвэл сарын хугацаанд хамгийн багадаа 535, хамгийн ихдээ 941 импорт, экспортын лицензийг, харин өдөрт 25-42 импортын лицензийг хянаж, боловсруулан олгосон байна. (Зураг 24.)

Зураг 24. Олгосон импортын лицензийн тоо, сараар, 2022 он



Олгосон импортын лицензийг төрлөөр нь авч үзвэл Эм, эмийн түүхий эд, стандарт бодисын 3188, Эмнэлгийн хэрэгсэл, эмийн туслах материалын 3987, Оношлуур урвалжийн 1203, Хандив тусламжийн 91, Төрийн хяналттай лиценз 155, Мансууруулах сэтгэгдэд нөлөөт эмийн 98 лицензийг 2022 онд олгосон байна.


2021 онтой харьцуулахад эм, эмийн түүхий эд, стандарт бодист олгосон импортын лиценз 190 нэгжээр, Эмнэлгийн хэрэгсэл, эмийн туслах материалын лицензийн тоо 282 нэгжээр тус тус өссөн бол Оношлуур урвалжийн лицензийн тоо 281 нэгжээр, Хандив тусламжийн импортын лиценз 600 нэгжээр, Төрийн хяналттай лиценз 200 нэгжээр, Мансууруулах, сэтгэгдэд нөлөөт эмийн импортын лиценз 3 нэгжээр тус тус буурсан байна. (Зураг 25.)

Зураг 25. Олгосон импортын лицензийн тоо, төрлөөр, 2021-2022 он



2022 онд 637,5 тэрбум төгрөгийн эм импортлогдсоноос 57.4% Алтанбулаг, 107,984 тэрбум төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл импортлогдсоноос 47.6% Замын-үүд, 41.8% Чингис хаан боомтоор, 54,8 тэрбум төгрөгийн оношлуур, урвалжийн импортлогдсоноос 87.8% Чингис хаан боомтоор, 25,8 тэрбум төгрөгийн түүхий эд импортлогдсоноос 52.3% нь Алтанбулаг, 42.7% Замын-үүд хилийн боомтоор тус тус импортлогдсон байна. (Зураг 26.)

Зураг 26. Импортлосон бүтээгдэхүүний мөнгөн дүн, тэрбум төгрөгөөр, хилийн боомтоор, 2022 он



2.4.7. ЭМИЙН ЭКСПОРТ

Манай улс уламжлалт эмийг ихэвчлэн Бүгд Найрамдах Унгар улс болон Бүгд найрамдах Польш улс руу экспортлож байна.

2022 онд 730,154,766 сая төгрөгийн 226 нэр төрлийн 36307 ширхэг уламжлалт эмийн (тан эм, талх эм, үрэл эм, тунлагдсан нунтаг) экспорт хийсэн байна.


2021 онтой харьцуулахад эмийн экспорт 188.7 сая төгрөгөөр буюу 20.5 хувиар буурсан байна. (Хүснэгт 10.)

Хүснэгт 10. Экспортлосон уламжлалт эм мөнгөн дүнгээр, сая төгрөгөөр 2021-2022 он

№	Эмийн хэлбэр	2021 он			2022 он		
		Нэр төрөл	Тоо хэмжээ	Мөнгөн дүн, сая төгрөгөөр	Нэр төрөл	Тоо хэмжээ	Мөнгөн дүн, сая төгрөгөөр
1	Тан эм	38	22642	245,822,100	51	7,339	120,029,038
2	Талх эм	104	30,222	320,746,800	122	15,101	306,436,828
3	Тунлагдсан нунтаг	5	15,731	89,666,700	11	7,283	49,374,750
4	Үрэл эм	42	8,998	262,583,800	42	6,584	254,314,150
Нийт дүн		189	77,593	918,819,400	226	36,307	730,154,766

2022 онд тан эм 118.3 сая төгрөг, талх эм 306.4 сая төгрөг, тунлагдсан нунтаг 49.3 сая төгрөг, үрэл эм 254.3 сая төгрөгийн экспорт хийжээ. (Зураг 27.)

Зураг 27. Экспортлосон эмийн мөнгөн дүн, сая төгрөгөөр, 2020-2022




2.4.8.ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТ

Улсын хэмжээнд 2022 онд нийт 101.96 тэрбум төгрөгийн 539 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн, уламжлалт эм, ариутгал халдваргүйтгэлийн бодис үйлдвэрлэж, 94.9 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.

2021 онтой харьцуулахад нийт үйлдвэрлэл 4.05 тэрбум буюу 4.0 хувиар, нийт борлуулалт 2.9 тэрбум төгрөгөөр буюу 2.9 хувиар тус тус буурсан байна.

2022 онд үндэсний үйлдвэрийн ариутгал халдваргүйтгэлийн бодис, уламжлалт эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгслийн борлуулалт тус тус буурч, эмийн борлуулалт өссөн байна. (Зураг 28.)

Зураг 28. Үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, тэрбум төгрөгөөр, 2018-2022он



Үүнээс: 77.9 тэрбум төгрөгийн европ эм үйлдвэрлэж, 69.2 тэрбум төгрөгийн борлуулалт, 14.2 тэрбум төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэж, 17 тэрбум төгрөгийн борлуулалт, 3.2 тэрбум төгрөгийн биологийн идэвхт бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 2.6 тэрбум төгрөгийн борлуулалт, 4 тэрбум төгрөгийн уламжлалт эм үйлдвэрлэж, 2.9 тэрбум төгрөгийн борлуулалт, 2.5 тэрбум төгрөгийн ариутгал халдваргүйтгэлийн бодис үйлдвэрлэж, 3 тэрбум төгрөгийн борлуулалт тус тус хийсэн байна. (Хүснэгт 11.)

Хүснэгт. 11 Үндэсний үйлдвэрийн үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний нэр төрөл, мөнгөн дүн, тэрбум төгрөгөөр, 2022 он

№	Ангилал	Үйлдвэрийн тоо	Нэр төрөл	Үйлдвэрлэсэн		Борлуулалт	
				Тоо ширхэг	Мөнгөн дүн, тэрбум төгрөгөөр	Тоо ширхэг	Мөнгөн дүн тэрбум төгрөгөөр
1	Эм	11	190	41,600,030	77,974,358,931	37,692,538	69,265,313,180
